МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 08 өдөр Дугаар А/572 Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант суманд өвөлжилт хүндэрч их хэмжээний цас орсонтой холбогдуулан эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:
Б.Должинсорогдог (Орон нутгийн өмчийн газрын дарга)

Гишүүдэд:
С.Ганболд (Онцгой байдлын газрын төлөвлөлт, бэлтгэл бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн хошууч)
Б.Сожидмаа (Мал эмнэлгийн газрын халдвартын их эмч)
Б.Энхмаа (Ус цаг уур орчны шинжилгээний төвийн цаг уурын инженер)
Ц.Хадбаатар (Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн)
Ш.Тогтохбаяр (Хөвсгөл нуур-Эгийн голийн сав газрын захиргааны жолооч)

Нарийн бичгийн дарга:
Х.Сайнбуян (Хүнс хөдөө аж ахуйн газрын мал үржлийн албаны мэргэжилтэн)

2. Нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, эрсдэлийн үнэлгээг хийж аймгийн онцгой комисст танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Должинсорогдог)-д даалгасугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА М. ХУЯГБААТАР

Захирамж-2023

6712011287